

ОЮУТНЫ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЧАНАРТ ХИЙСЭН СУДАЛГАА

С.Ганцэцэг, Э.Оюун-Эрдэнэ
Мандах их сургууль, УБ хот
gantsetseg@mandakh.edu.mn,
e.oyunerdene@mandakh.edu.mn

Хураангуй.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын боловсролын салбарт үр дүн, технологи болон хамтын оролцоонд суурилсан суралцахуйн стратегийг ашиглах хандлага ихээхэн дэлгэрч байгааг зэрэгцээ Их дээд сургуулийн багш нарт судлаач, шинжээч байх чадамж, нөгөө талаас оюутан, суралцагчдад судалгааны арга зүйн дадал чадвар, ёс зүйг төлөвшүүлэх харилцан уялдаатай үйл явц багш судлаачдын өмнө урган гарч байна. Энэхүү судалгааны ажлаар их дээд сургуулийн оюутнуудын судалгааны ажлын чанарт ахиц гарч байгаа эсэхийг Мандах их сургуулийн жишээн дээр судалж тодорхойлохыг зорив. Тус судалгааны ажлын үр дүнд оюутны судалгааны ажлын чанарыг 1) оюутнууд сургуулийн эрдэм шинжилгээний бичвэрийн стандартыг мөрдөж хэвшиж байгааг 2017-2019 оны оюутны бүтээлийн харьцуулалтаас гарсан ялгаатай байдал, 2) оюутны судалгааны ажлын арга зүй болон оюуны өмчийн ёс зүйн зарчмыг баримтлах дадал төлөвшиж байгааг хуулбарлалт илрүүлэх програм нэвтрүүлсэнтэй холбон дүгнэлт өгсөн. Харин удирдагч багшийн чиглүүлэх аргазүйн хувьд багш нар зөвхөн оюутны эрдэм шинжилгээний хурлын үед л хуралд оролцох сонирхолтой оюутнуудад зөвлөж ажилладаг буюу байнгын хамтарсан судалгааны ажилд хараахан нэгдэж чадаагүй үр дүн гарлаа. Энэ нөхцөл байдал нь оюутан багшийн хамтарсан судалгааны ажлын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллахыг хэвшүүлэх шаардлагатайг харуулж байна. Энэ судалгааны ажлын үр дүнд Мандах их сургуулийн багш судлаачид сургуулийн алсан хараа, эрхэм зорилгод хүрэх зорилтуудыг алхам алхамаар хэрэгжүүлж байгааг тодорхойлсон ач холбогдолтой ажил гэж үзэж байна.

Түлхүүр үг: оюутны эрдэм шинжилгээний ажил, бичвэрийн стандарт, удирдагч багшийн чиглүүлэх арга барил, судалгааны ажлын ёс зүйн төлөвшил

Оршил

Өнөө үед дэлхий дахинаа “бид хариуцлагатайгаар аж төрөх учиртай” гэсэн үзэл санаанд нэгдэн Тогтвортой хөгжлийн тухай 17 зорилго 169 зорилт бүхий тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг 2015 оны 9 дүгээр сард батлан гаргасан бөгөөд Дэлхийн тогтвортой хөгжлийн дөрөвдүгээр зорилгод Боловсролтой холбоотой “Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” ерөнхий зорилгын дор

Боловсролын чанар, Насан туршийн суралцахуй зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Дэлхийн улс орнууд энэхүү зорилгод нэгдэн уялдаа бүхий өөрийн улс орны бодлогоо төлөвлөн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 нь дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хөтөлбөртэй нягт уялдаатай төлөвлөгдсөн ба “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүн” зорилтын хүрээнд дээд боловсролын тогтолцоог тэгш, хүртээмжтэй, чанартай болгох; үндэсний 4-өөс доошгүй сургуулийг азийн шилдэг сургууль болгох; олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх төгсөгчид бэлтгэн гаргах зорилтууд дэвшүүлсэн байна.

Судлагдсан байдал

Канадын Кюбек Их сургуулийн эрдэмтэн Мартин Петерс, Тесса Бойес, Сониа Мориэн нар судалгааны ажлын ёс зүйд оюутнууд хэрхэн суралцдаг талаар судлахаар 6 их дээд сургуулийн багш нараас оюутны судалгааны ажилд зориулан мэдээлэл олж авах, дүгнэх, задлан шинжлэх боловсруулахад зөвлөх, судалгааны ажлыг бичих, эшлэл зүүлт татах, мөн хуулбарлалтаас сэргийлэх талаар хэрхэн зөвлөгөө өгч буй болон багш нарын үүрэг оролцооны талаас авч үзэхдээ 49 профессорыг оролцуулан ярилцлагын судалгаа авч судласан байна.

Судлаач, эрдэмтэн М.Золзаяа “Эрдэмтний ёс зүйн тухайд” бүтээлдээ судалгаа шинжилгээний ажилд аливаа хүн өөрийн мэргэжлийн ба шинжлэх ухааны ёс зүйн шаардлагуудыг баримталж, шинжлэх ухааны мэдлэгийг бүтээх, эзэмших, түгээн дэлгэрүүлэх, түүний үр дүн, нээлтийг зохистой, зөв ашиглах үйл ажиллагаатай холбоотой ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг мөрдөх шаардлагатай байдаг гэж судлаачийн ёс зүйн талаар тэмдэглэсэн байна.

Судлаач Б. Мөнхбуян “Зохиолын хулгайг илрүүлэх асуудалд” бүтээлдээ зохиолын хулгайг илрүүлэх орчин цагийн шаардлага, хууль эрх зүйн орчинг дүгнэж, зохиолын хулгайн хэлбэрүүд болон тэдгээрийг таних аргууд, илрүүлэх онлайн системийн боломжууд, бүтээлийн хулгайг илрүүлэх монгол системийг бүтээх төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай сангуудыг тодорхойлохыг зорьсон байна. Тэрээр тус

өгүүлэлдээ “...шууд хуулсан, зшлэл будлиулсан, үг сольсон, гишүүн өгүүлбэрийн байрлал сольсон, өгүүлбэр зүйрлэсэн, холимог зохиолын хулгайн хэлбэрүүд нь өгүүлбэр, догол мөр, бүлгийн хэмжээнд үйлдэгддэг тул хэсэгчилсэн зохиолын хулгайн хэлбэр; зохион байгуулалтыг хуулсан, хэлбэр өөрчилсөн, санаа хуулсан, орчуулсан зохиолын хулгайн хэлбэрүүд нь бүтэн зохиолын хулгайн хэлбэр” гэж тодорхойлон бичжээ.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны өгүүллээр 2017, 2018, 2019 оны хичээлийн жилүүдэд Мандах их сургуулийн оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн 34 оюутны илтгэл, бакалаврын дипломын хамгаалалт хийсэн 35 оюутны судалгааны ажлын бичвэрийн стандартад рубрикийн аргаар үнэлгээ хийж оноожуулан дүгнэлт өгч Desk analysis хийсэн. Мөн оюутан судалгааны ажил хийх арга зүйд хэрхэн суралцаж байгаа, тэдний судалгааны ажлын ёс зүй хэрхэн төлөвшиж байгааг тодорхойлох үүднээс Мандах их сургуулийн 31 багшаас асуулгын аргаар судалгаа авч SPSS програмаар үр дүнг нэгтгэн гаргаж дүгнэлт өгөв.

Үндсэн хэсэг

Их дээд сургуулиуд нь улс орны хөгжлийн ирээдүй болсон өндөр мэдлэг, чадвар, хандлага бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэж, сургалт, нийгмийн үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гэсэн үндсэн гурван чухал үүргийг гүйцэтгэдэг. Доктор, профессор Д. Бадарч нарын эрдэмтэд “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” бүтээлдээ “Дэлхий дахинаа эргэлт буцалтгүй баттай тогтож байгаа мэдлэгийн нийгэмд хөл нийлүүлэн алхаж, мэдлэгийн эдийн засгийн өрсөлдөөнд өөрийн байр сууриа эзлэхийн тулд хөгжиж байгаа орнууд судалгааны их сургууль байгуулахад чухал анхаарал тавьж байна.

Судалгааны их сургууль бол тодорхой чиглэлээр мэдлэгийг бүтээх, түгээх үүрэгтэйн дээр ялангуяа хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжил дэвшилд маш их үүрэг гүйцэтгэдэг” хэмээн тэмдэглэсэн байна. Судалгааны их сургуулийн нэг үзүүлэлт бол бэлтгэн гаргаж байгаа магистр, докторын зэрэгтэй мэргэжилтний тоо, тэдгээрийн бүтээл байхын зэрэгцээ төгсөгчдийн ажил эрхлэлт, бүтээл туурвил зэрэг нь чухал үзүүлэлт болж өгдөг. Дэлхийн улс орнууд дээд боловсролын хөтөлбөрөөр суралцагчдад онолын мэдлэг, түүнийг дагасан чадваруудыг эзэмшүүлэхэд түлхүү анхаарч байсан бол энэ хандлага шинэ зууны эхнээс эрс өөрчлөгдөж тухайн шинжлэх ухааны салбар чиглэлийн мэдлэг, чадваруудаас гадна хувь хүний болон харилцааны чадвар, хандлагуудыг давхар эзэмшүүлэх, хөгжүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлж, суралцахуйн үйлийг үр дүн талаас нь мэдлэг, чадвар, хандлага буюу ерөнхийд нь цогц чадамж ба суралцахуйн үр дүн (Learning outcome) гэж томъёолж байна.

Анагаах ухааны доктор, профессор Ж.Цолмон “...Их, дээд сургуулийн чанар, чансааг эрэмбэлэх шалгуурын дийлэнх нь эрдэм шинжилгээ, судалгаатай холбоотой үзүүлэлтүүд эзэлж байна. Иймд оюутанд судалгаа хийх ур чадварыг эзэмшүүлэхийн тулд бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх, одоогийн сургалтын хөтөлбөр, судалгаа хийх орчныг сайжруулах, оюутны эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, тэднийг урамшуулах, судалгааны тэтгэлгүүдийг нэмэгдүүлэх, судалгаан дахь оюутны оролцоог нэмэгдүүлэх шаардлага тулгарсаар байгаа юм” хэмээн ярилцлагадаа дурьджээ.

Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “судалгаа” гэдэг үгийг судлах үйлийн нэр гэж тайлбарласан байдаг. Судалгааны ажил нь оюутнууд мэргэжилээрээ бие дааж судалгааны ажил хийх аргачилалд суралцах, эх сурвалжууд ашиглан тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судлах, онолын мэдлэгийг бататгах, гүнзгийрүүлэх, бие даасан үйл ажиллагааны дадал зүй эзэмшүүлэх зорилго бүхий эргэцүүлэн бодох, дүгнэлт гаргах тэдгээрийг дэс дараалалтай, баталгаа нотолгоотой бичих чадвар суулгах мөн бакалаврын төгсөлтийн ажлыг бичих дадал олгох зорилго бүхий багшийн удирдлаган дор хийх мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн үндсэн хичээлээр дагнан хийдэг ажил юм.

Оюутан, судлаачдын оюуны бүтээлийг шалгах, баталгаажуулах, хамгаалах, тэдгээрийн судалгааны арга барилыг дээшлүүлэх зорилгоор “Оюуны бүтээлийн хуулбарлалтаас сэргийлэх олон улсын жишигт нийцсэн цогц систем”-ийг албан ёсоор Монгол улсын их дээд сургуулиуд хэрэгжүүлж эхэлж байна.

Удирдагч багш оюутанд сэдвээ сонгох чиглэл, сэдвийн дагуух онол арга зүйн зөвлөгөө өгөх, бакалаврын төгсөлтийн болон курсын ажлын агуулга бүтцийг батлах, судалгаа шинжилгээ хийхэд шаардагдах тоо мэдээлэл, хүснэгт маягтыг боловсруулахад туслах, ашиглах ном, сурах бичиг эх материалыг зааж өгөх, бичилтийн явцад хяналт тавих, баталсан график төлөвлөгөөний биелэлт өгсөн заавар зөвлөгөөний хэрэгжилтийг хянаж ажиллах үүрэгтэй байдаг.

Доктор, профессор Д.Бадарч “...Үүнтэй уялдан судалгааны их сургуулийн эрдэмтэн профессорууд нь байнга шинийг эрэлхийлж, судалгааны арга зүйгээ хөгжүүлж, эрдэм шинжилгээний ажлынхаа үр дүнд шинэ онол дэвшүүлж, өөрийн судалгааны ажилдаа шүүмжлэлтэй хандаж, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд бүтээлээ тогтмол нийтлүүлдэг байх, зохиогчийн эрхийн хэм хэмжээг ягштал баримталж, бусдын бүтээлийг хуулах, зөвшөөрөлгүй ашиглахаас татгалзаж, жинхэнэ шинэлэг бүтээл туурвих үүргийг профессор багш нар хүлээдэг” гэж онцлон дурьджээ.

Судлаач эрдэмтэн Ц. Дэмбэрэл: “Барууны судлаачид бол сэтгэлгээ, хандлагыг түлхүү чухалчилна. Тэд бүтээлчээр ургуулан сэтгэх, гүн


логиктой эрэмбэ цэгцтэй сэтгэх, тунгаан бодож шүүж сэтгэх, багаар хамтран ажиллах зэрэг оюун сэтгэлгээний дээд эрэмбийн чадварт гаршжээ. Боловсрол нь ч тийм болсон байна” хэмээн нийтэлсэн байна.

Тус судалгааны ажлын зорилгын хүрээнд Мандах их сургуулийн жишээнд суурилан оюутны эрдэм шинжилгээний ажлын чанарын асуудлыг хөндөж асуулгын аргаар цуглуулсан мэдээлэлд SPSS програмаар үр дүнгийн шинжилгээ хийхийн зэрэгцээ 2017-2019 оны оюутнуудын бакалаврын диплом болон эрдэм шинжилгээний хурлын эмхтгэлд Desk analysis хийж үр дүнг доор тайлагнаж байна.



Зураг 1. Асуулгын судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Оюутны судалгааны ажлын чанарт удирдагч багшийн чиглүүлэх арга барил хэрхэн нөлөөлж байгааг асуулгын аргаар 31 багшаас авч, тэдний ерөнхий мэдээллийг насны ангилал, мэргэжлийн зэрэг, цол болон багшилсан жилийн туршлага зэрэг ангиллаар илэрхийлэв. Судалгаанд оролцогч багш нарын ихэнх хувь /41.9% ба 35.5%/ нь 30-49 насны бүлгийнхэн, 48.4% нь магистр зэрэгтэй багш нар байгаа бөгөөд 6-10 болон 16-20 жилийн ажлын туршлагатай багш нар бусдаасаа илүү хамрагдсан үзүүлэлттэй байна.



Зураг 2. Удирдагч багш нарын чиглүүлэх зөвлөгөө

Удирдагч багш нар оюутны судалгааны ажлын чанарыг дээшлүүлэхэд эрдэм шинжилгээний албан ёсны эх сурвалжуудыг ашиглах, эш авах зэргээр тэдний судалгааны ажлын чанарт анхаарч ажилладаг нь судалгааны дата мэдээллийг цуглуулахад зөвлөдөг аргачлалаас нь харагдаж байна. Мөн багш нар эрдэм шинжилгээний ажлын нарийн логик уялдааг баримтлах арга зүйн зөвлөгөөг /61.3%/ судлаачийн ёс зүйн зарчимтай хослуулан зөвлөх /80.6%/ замаар оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ахицад анхаардаг нь ажиглагдаж байна.



Зураг 3. Ёс зүйн баталгаажуулалт

Оюутны судалгааны ажлын онол аргагүйн түвшинг дээшлүүлэхэд зохиогчийн эрхийн хэм хэмжээг баримталж, бусдын бүтээлийг хуулбарлахгүйгээр эш татан өөрийн ажлаа баяжуулах, улмаар шинэ санаа бүхий өөрийн бүтээл туурвихын зэрэгцээ өмнө дурьдсанчлан судлаачийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж сурах талаар удирдагч багш нар зөвлөж ажиллаж байна. Үүний зэрэгцээ Мандах их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны хорооноос 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн “Plagscan” хуулбарлалтаас сэргийлэх программыг нэвтрүүлсэнээр бакалаврын диплом бичиж буй нийт оюутнуудын дипломын ажлын хуулбарлалт 15%-иас доош хувьтай шалгагдсан нь оюутнуудын судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээ төлөвшиж байгааг илэрхийлэх бодитой үр дүн гэж харж байна.

Хүснэгт 1. Судалгааны ажлыг чиглүүлэх арга

Судалгааны ажлыг удирдан чиглүүлэх хэлбэр	Responses		Percent of Cases
	N	Percent	
Оюутанд судалгааны ажил хийх зөвлөмжийг хичээлийн хөтөлбөртөө тусган заадаг.	10	17.2%	32.3%
Бусад багш нартайгаа хамтран оюутны судалгааны ажилд идэвхитэй зөвлөдөг.	4	6.9%	12.9%
Шаардлагатай тохиолдолд судалгааны аргагүйн талаар оюутандаа зөвлөдөг.	16	27.6%	51.6%
Оюутныг веб хуудсанд байрших судалгааны аргагүйн зөвлөмжийг уншиж судлан, бие даан суралцахыг дэмждэг.	12	20.7%	38.7%
Бакалаврын оюутнуудад судалгааны аргагүйд суралцахад чиглүүлэх тусгай хөтөлбөр, хичээл заадаг байх саналыг дэмжинэ.	11	19.0%	35.5%
Өөрийн заадаг хичээлийн чанарт анхаарч ажилладаг	5	8.6%	16.1%
Total	58	100.0%	187.1%

Асуулгын судалгааны үр дүнд багш нар оюутны эрдэм шинжилгээний хурал, бакалаврын болон магистрын дипломын ажил зэрэг судалгааны ажлыг удирдах тухайн шаардлага гарсан буюу өөрөөр хэлбэл, эрдэм шинжилгээний хурал зарлагдсан үед нь удирдан чиглүүлдэг гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь багш оюутны хамтарсан судалгааны ажлын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах шаардлагатай байгааг харуулж

байна. Үүнээс улбаалан бид удирдагч багшийн зөвлөх үйлчилгээг тэдний мэргэжлийн зэрэгтэй хамааруулан доорх хүснэгтээр харуулахыг оролдлоо.

Хүснэгт 2. Удирдагчийн мэргэжлийн зэрэглэл болон зөвлөгөөний хамаарал

	Судалгааны аргазүй болон судлаачийн ёс зүйн зөвлөгөө		Хуулбарлалтын эсрэг программын талаарх зөвлөгөө			
	Аль алиныг нь зөвлөдөг	Аргазүйн талаар зөвлөдөг боловч, ёс зүйн талаар төдийлөн зөвлөдөггүй.	Зөвлөгөө өгдөггүй	Тийм	Үгүй	Хариулах боломжгүй
Доктор, профессор	6,5%	3,2%		9,7%		
Доктор, дэд профессор	9,6%			9,7%		
Магистр, ах/багш	25,8%	6,5%		25,8%	3,2%	3,2%
Магистр багш	38,7%	6,5%	3,2%	38,7%	6,5%	3,2%


Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн дагуу энэ судалгаанд доктор профессор болон доктор дэд профессорын зэрэг цолтой багш нарын 83,3%, магистр зэрэгтэй багш нарын 80% нь судалгааны ёс зүйн зөвлөгөөг өгч ажилладаг байна. Харин доктор зэрэгтэй багш нарын 17,7%, магистр зэрэгтэй багш нарын 16% нь зөвхөн судалгааны арга зүйн зөвлөгөөг өгч ажилладаг бөгөөд ёс зүй болон хуулбарлалтыг илрүүлэх програмын талаар санал зөвлөгөө хангалттай өгдөггүй байгаад цаашид анхаарах болж байна. Мөн огт зөвлөгөө өгдөггүй багш нар 4%-ийг эзэлж байгааг цаашид оюутны эрдмийн ажлын чанарыг сайжруулахад анхаарах зүйл гэж харж байна.

Хүснэгт 3. Удирдагч багшийн мэргэжлийн зэрэглэл болон удирдан зөвлөх аргын хамаарал

\$Q7.1*Q2 Crosstabulation					
	доктор, проф	доктор, дэд/проф	магистр, ах/багш	Маг/багш	Total
Оюутанд судалгааны ажил хийх зөвлөмжийг хичээлийн хөтөлбөртөө тусган заадаг.	1	0	2	7	10
Бусад багш нартайгаа хамтран оюутны судалгааны ажилд идэвхитэй зөвлөдөг.	1	1	2	0	4
Шаардлагатай тохиолдолд судалгааны аргазүйн талаар оюутандаа зөвлөдөг.	1	3	5	7	16
Оюутныг веб хуудсанд байрших судалгааны аргазүйн зөвлөмжийг уншиж судлан, бие даан суралцахыг дэмждэг.	1	0	4	7	12
Бакалаврын оюутнуудад судалгааны аргазүйд суралцахад чиглүүлэх тусгай хөтөлбөр, хичээл заадаг байх саналыг дэмжинэ.	2	2	3	4	11
Өөрийн заадаг хичээлийн чанарт анхаарч ажилладаг	0	0	3	2	5

Багшийн удирдах арга болон зэрэглэлийн хамаарлын хүснэгтээс харахад хүснэгт 1-ээр илэрхийлсэн тооцооллын дүн батлагдаж байгаа буюу цаашид оюутан багшийн хамтарсан судалгааны ажлын тасралтгүй хөгжлийг хангаж ажиллах шаардлага байна гэж үзэж байна.

Оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл болон бакалаврын дипломын бичвэрийн стандартыг хангасан байдалд нийт 69 оюутны ажилд баримтын шинжилгээ /Desk analysis/ хийж, судалгааны өгүүллийн бүтцийн элемент бүрийг /хураангуй, удиртгал, арга зүй, үр дүн, дүгнэлт, хэлэлцүүлэг, ашигласан материал/ рубрикийн аргаар үнэлж дүгнэв.



Зураг 4. Оюутны судалгааны ажлын бичвэрийн стандарт баримталсан байдал

Дээрх зургаас харахад магистр, бакалаврын диплом бичиж буй оюутнууд бичвэрийн стандартыг сайн баримталж байгаа хэдий ч бакалаврын түвшний оюутны эрдэм шинжилгээний хурлын бүтцийн үнэлгээ төдийлөн шаардлага хангахгүй буюу 65,2%-тай байгаагаас харагдаж байна. Үүнээс үүдэн сургуулийн болон судалгааны багийн түвшний хуралд оролцож байгаа оюутнуудын мэдээлэлтэй ажиллахад анхаарах шаардлага гарч байна. Харьцуулсан хичээлийн жилийн мэдээллээр 2018 оны үзүүлэлт 2017 оныхоос буурсан байгаа ч 2019 онд өссөн дүнтэй байгаа нь өмнөх жилийн алдаанд үнэлэлт өгч оюутны судалгааны ажлын чанарыг сайжруулахад эргэх холбоотой ажиллаж байна гэж үзэж байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүнд үнлэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг гаргаж байна.

- Оюутнуудын академик чадвар буюу мэдээллийг боловсруулан ажиллах, хуулбарлалтаас зайлсхийх арга техник эзэмших зэрэг судалгааны ажлын ёс зүйн зарчмыг баримтлах хандлага их дээд сургуулийн оюутнуудад төлөвшиж байна.
- Оюутны эрдэм шинжилгээний ажлын арга зүйн болон ёс зүйн хэм хэмжээ төлөвших хандлагатай байгаа ч бакалаврын түвшний судалгааны ажлын бичвэрийн стандарт, логик уялдааг хангаж ажиллахад багш, оюутны хамтарсан судалгааны ажлыг тасралтгүй явуулж хэвшүүлэх шаардлагатай байна гэж дүгнэж байна.
- Судалгааны ажлын тасралтгүй үйл явцын дүнд их дээд сургуулийн багш судлаачид,

судлаач оюутнууд сургуулийн алсын хараа, эрхэм зорилго болоод чанартай боловсролоор тогтвортой хөгжлийн зорилтуудыг алхам алхамаар хэрэгжүүлж байгаа ажлын нэг гэж үзэж байна.

STUDY ON QUALITY FACTORS OF STUDENTS' RESEARCH WORK

Abstract

In recent years global countries have taken consideration into applying outcome-based, technology and cooperation-based learning strategies in teaching of tertiary education. Simultaneously, in this information era, challenges of both learners and educators have emerged relating to the issues that teachers in higher education are required to be skillful scholars and researchers, on other hand, undergraduates and graduates are needed to acquire research methods and academic integrity.

This paper was produced to investigate circumstance in engagement of students' research work and to analyze key parameters covering the collection of bachelor's and master's thesis, scholarly papers done by students of Mandakh University in the given academic years, 2017-2019, through Desk analysis and SPSS programs. According to findings the most effective variables were shown as bellowed that: 1) academic research standards, 2) research ethics, 3) supervising approaches in terms of the academic integrity. The significance of this study was identified one of the factors in quality of research work were academic integrity; the vision objectives of Mandakh University were implemented step by steps by teachers.

Key words: student's research work, academic research standards, supervising approaches, research ethics

Зохиогчийн тухай

Санжмятавын Ганцэцэг: Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийг англи-орос хэлний багшийн мэргэжлээр төгссөн. Тайланд улсын Махасарахам их сургуульд Соёл судлалын ухааны докторын зэрэг хамгаалсан. Хэл соёлын шүтэлцээ, боловсрол судлалын чиглэлээр судалгаа хийдэг.

Эрдэнэбилэгийн Оюун-Эрдэнэ: Монгол Улсын Боловсролын их сургуулийг англи хэлний багш-орчуулагч мэргэжлээр төгссөн. МУБИС-ын Боловсрол судлалын докторант. Гадаад хэл заах арга зүй, боловсрол судлалын чиглэлээр судалгааны ажил хийдэг.

Ном зүй

1. Б.Мөнхбуян. (2017). [mmt.edu.mn: http://mmt.edu.mn/static/upload/old_paper/2017/2017-04-26_145039.019262.pdf](http://mmt.edu.mn/static/upload/old_paper/2017/2017-04-26_145039.019262.pdf)-ээс
2. Д.Бадарч.(2017).Дээд боловсролын өөрчлөлт-1 Судалгааны их сургууль. Улаанбаатар, Монгол Улс.
3. Ж.Цолмон. (2019). Ж.Цолмон: АШУУИС судалгааны их сургууль болно. <https://www.mnuns.edu.mn/newsView.php?post=2929&lang=mn-ээс> Гаргасан
4. Зөвлөмж, “ ш. (2016). <https://www.must.edu.mn/en/news/6043-ээс> Гаргасан
5. М.Золзаяа "Эрдэмтний ёс зүйн тухайд". (2018 оны 07 27). mnб.mn: <http://www.mnb.mn/i/147686-ээс> Гаргасан
6. Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн их сургууль . (2019). Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. Улаанбаатар хот: ШУТИС Н.Эрдэнэхүү. (2018 оны 10). research gate. <https://www.researchgate.net/publication/328333867-ээс> Гаргасан
7. Ц.Дэмбэрэл. (2019 оны 12 19). <http://www.baabar.mn/article/sudalgaanii-ikh-surguuli-ba-durwun-shinechlel-ээс> Гаргасан
8. Ц.Оюун. (2016). Дээд боловсролын инновацид эрдэмтэд, багш нарын оруулах хувь нэмэр. Лавай Эрдэм шинжилгээний бичиг , 160-165.
9. Martin Peters, Т. В. (2019). Teaching academic integrity in Quebec Universities: Roles professors adopt. Frontiers in Education Sep 19, Volume 4, Article 99, 1.